



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/062НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

АХБ.СБ.ДЗ № 121

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮЕНЧ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Т.ТОГТОХБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар багийн бага сургуульд баригдаж сургуулийн өмнөх боловсролын 2 бүлэг шинээр нэмэгдэж 70 гаруй хүүхдийг хамруулж, улсын төсвөөс 1,426,874.9 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 2 дугаар түвшинд 4 багш, 3 дугаар түвшинд 1 багш, 4 дүгээр түвшинд 3 багш, 5 түвшинд 1 багш үнэлэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

8426050246  
А4-тоот-2026

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>154,851,269.99</u></b>	<b><u>98,668,159.44</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	103,582,857.65	36,697,179.71
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	103,582,857.65	36,697,179.71
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	103,582,857.65	36,697,179.71
31211	Төрийн сангийн харилцах	103,582,857.65	36,697,179.71
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	781,312.34	1,243,103.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	587,851.95	728,634.82
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	193,460.39	514,468.65
3351	Байгууллагаас авах авлага	193,460.39	514,468.65
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	50,487,100	60,727,876.26
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,679,600	45,519,376.26
35110	Тусгай зориулалттай материал	43,679,600	45,519,376.26
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6,807,500	15,208,500
35420	Аж ахуйн материал	-	1,850,000
35470	Бусад хангамжийн материал	6,807,500	13,358,500
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>995,489,571.94</u></b>	<b><u>1,032,967,825.29</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	995,489,571.94	1,032,967,825.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	983,489,571.94	1,020,967,825.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	968,469,411.83	968,469,411.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(93,397,901.79)	(110,073,527.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,714,076	130,985,203.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,342,107.02)	(36,953,713.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,270,949.03	104,700,643.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,267,755.51)	(38,509,002.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,396,023	9,396,023
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,577,411.60)	(7,047,212.80)
39217	Ном	3,224,288	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,000,000	12,000,000
39301	Програм хангамж	198,432	198,432
39302	Хуримтлагдсан элэгдэл	(198,432)	(198,432)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000	12,000,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,150,340,841.93</u></b>	<b><u>1,131,635,984.73</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.10</b>	<b><u>1,675,537.78</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.10	1,675,537.78
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.10	1,675,537.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.10	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,675,537.78
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,150,340,841.83</u></b>	<b><u>1,129,960,446.95</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,150,340,841.83	1,129,960,446.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,504,224	122,504,224
51101	Өмч: - төрийн	122,504,224	122,504,224
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	654,255,366.83	634,177,413.86
51210	Өмнөх үеийн үр дүн	654,255,366.83	654,557,808.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	(20,380,394.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	373,581,251	373,278,809.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,150,340,841.93</u></b>	<b><u>1,131,635,984.73</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,389,291,482</b>	<b>1,406,091,925.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>53,188,382</b>	<b>77,931,025.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	53,188,382	77,931,025.25
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,150,282	76,841,248.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,038,100	1,089,776.26
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,336,103,100</b>	<b>1,328,160,900</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,246,160,300	1,244,583,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,246,160,300	1,244,583,300
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	89,942,800	83,577,600
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,942,800	83,577,600
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,258,290,181.77</b>	<b>1,423,248,032.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,258,290,181.77</b>	<b>1,423,248,032.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,235,220,481.77	1,410,532,094.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	840,207,044.16	1,019,137,179.14
210101	Үндсэн цалин	547,598,608.13	624,599,006.15
210102	Нэмэгдэл	241,066,425.68	320,332,522.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,305,000
210104	Урамшуулал	51,542,010.35	54,900,650
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	105,267,736.33	126,396,659.17
210201	Тэтгэврийн даатгал	71,560,136.33	87,076,421.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,426,900	9,859,139.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,213,500	5,157,575.02
210204	Ажилгүйдлийн даатгал	4,213,500	4,714,027.80
210205	Эрүүл мэндийн даатгал	16,853,700	19,589,495.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	82,002,836.73	82,687,968.78
210301	Гэрэл, цахилгаан	7,681,936.73	8,533,836.78
210302	Түлш, халаалт	73,634,100	73,634,132
210303	Цэвэр, бохир ус	686,800	520,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	131,916,243	108,642,050
210502	Хоол, хүнс	131,916,243	108,642,050
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,122,000	2,116,640
210604	Урсгал засвар	1,122,000	2,116,640
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,995,250	4,355,800
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,050,250	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	945,000	4,355,800
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	65,709,371.55	67,195,797.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,046,922	21,160,290.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,340,100	8,546,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	33,322,349.55	37,488,707.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,069,700	12,715,937.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,069,700	12,697,968.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,069,700	12,697,968.40
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	17,969
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,969
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>131,001,300.23</b>	<b>(17,156,106.88)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	(3,224,288)
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	(3,224,288)
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(3,224,288)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>131,001,300.23</b>	<b>(20,380,394.88)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,336,103,100</b>	<b>1,328,160,900</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,336,103,100</b>	<b>1,328,160,900</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,246,160,300	1,244,583,300
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,246,160,300	1,244,583,300
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	89,942,800	83,577,600
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,942,800	83,577,600
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,226,052,114.83</b>	<b>1,395,046,577.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,226,052,114.83</b>	<b>1,395,046,577.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,202,982,414.83</b>	<b>1,382,330,640.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	840,988,356.50	1,026,376,329.54
210101	Үндсэн цалин	548,379,920.47	640,981,654.92
210102	Нэмэгдэл	241,066,425.68	305,099,059.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,236,815.36
210104	Урамшуулал	51,542,010.35	61,058,800
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	105,267,736.33	119,619,300
210201	Тэтгэврийн даатгал	71,560,136.33	81,348,800
210202	Тэтгэмжийн даатгал	8,426,900	9,571,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,213,500	4,787,200
210204	Ажилгүйдлийн даатгал	4,213,500	4,787,200
210205	Эрүүл мэндийн даатгал	16,853,700	19,125,100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	85,672,800	81,292,431
210301	Гэрэл, цахилгаан	10,973,100	6,858,299
210302	Түлш, халаалт	73,634,100	73,634,132
210303	Цэвэр, бохир ус	1,065,600	800,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	120,898,100	108,642,050
210502	Хоол, хүнс	120,898,100	108,642,050
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,270,000	2,267,200
210604	Урсгал засвар	4,270,000	2,267,200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,819,400	5,105,800
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,724,400	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,095,000	5,105,800
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,066,022	39,027,530
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,038,122	31,130,730
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,027,900	7,896,800
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,069,700</b>	<b>12,715,937.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,069,700	12,697,968.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,069,700	12,697,968.40
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	17,969
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,969
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>110,050,985.17</b>	<b>(66,885,677.94)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,992,800</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,992,800</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	27,992,800	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,992,800	-

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(27,992,800)</b>	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	82,058,185.17	(66,885,677.94)
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		103,582,857.65
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	103,582,857.65	36,697,179.71

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	122,504,224	373,581,251	654,255,366.83	1,150,340,841.83
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>122,504,224</b>	<b>373,581,251</b>	<b>654,255,366.83</b>	1,150,340,841.83
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	122,504,224	373,581,251	654,255,366.83	1,150,340,841.83
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	122,504,224	373,581,251	654,255,366.83	1,150,340,841.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	302,441.91	302,441.91
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>122,504,224</b>	<b>373,581,251</b>	<b>654,557,808.74</b>	1,150,643,283.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(302,441.91)	-	(302,441.91)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(20,380,394.88)	(20,380,394.88)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	122,504,224	373,278,809.09	634,177,413.86	1,129,960,446.95

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,431,997,100	1,395,028,608.94
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,431,997,100	1,395,028,608.94
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,419,049,000	1,382,330,640.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,045,168,200	1,026,376,329.54
210101	Үндсэн цалин	635,481,300	640,981,654.92
210102	Нэмэгдэл	360,519,200	305,099,059.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,236,815.36
210104	Урамшуулал	49,167,700	61,058,800

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,412,600	119,619,300
210201	Тэтгэврийн даатгал	87,760,700	81,348,800
210202	Тэтгэмжийн даатгал	10,412,900	9,571,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,206,500	4,787,200
210204	Ажилгүйдлийн даатгал	5,206,500	4,787,200
210205	Эрүүл мэндийн даатгал	20,826,000	19,125,100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	81,310,400	81,292,431
210301	Гэрэл, цахилгаан	6,858,300	6,858,299
210302	Түлш, халаалт	73,652,100	73,634,132
210303	Цэвэр, бохир ус	800,000	800,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	116,580,100	108,642,050
210502	Хоол, хүнс	116,580,100	108,642,050
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,267,200	2,267,200
210604	Урсгал засвар	2,267,200	2,267,200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,105,800	5,105,800
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,105,800	5,105,800
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,204,700	39,027,530
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,468,500	31,130,730
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,736,200	7,896,800
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,948,100	12,697,968.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,948,100	12,697,968.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,948,100	12,697,968.40
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,431,997,100	1,328,142,931
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,348,419,500	1,244,583,300
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,348,419,500	1,244,583,300
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	83,577,600	83,559,631
132001	Орон нутгийн төсвөөс	83,577,600	83,559,631
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>103,582,857.65</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>36,697,179.71</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	37	35
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	26	24
620003	Үйлчлэх ажилтан	10	10
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1	1
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	1	1
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37</b>	<b>35</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24	23
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12

## ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 35,693.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 20,926.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд худалдан авсан 2,686.1 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг зарлагадаж бараа материалын үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн,
- өмнөх онд ашиглалтад орсон хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүй тухайн онуудын элэгдлийг бодоогүй хуримтлагдсан элэгдэл, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бууралтыг өмнөх үр дүн данс руу бичээгүй 5,837.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Хөрөнгийн ангилал буруу сонгон 2,805.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшлийг дансанд бүртгэсэн,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг, тайлант үеийн үр дүнг 9,598.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 14,766.7 мянган төгрөгийн 5 зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 14,766.7 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 11,981.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

#### 3.1.1 Цалин, төрийн алба хаасны нэмэгдэл, улирлын үр дүнгийн урамшуулал, илүү цагийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Багш нарт гүйцэтгэлийн үнэлгээгээр олгох хувь хэмжээг тогтоолд заасан хэмжээнээс илүү, ажилчдад илүү цагийн хөлс, төрийн алба хаасны нэмэгдэл, сахилгын арга хэмжээтэй албан хаагчид улирлын урамшуулалд нийт 11,981,251 төгрөгийг олгосон нь “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “ Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаал “ Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг нэлэх, дүгнэх” журмын 4.1-д “Боловсролын үнэлгээний байгууллага нь цэцэрлэгийн багшийн ажлын үнэлгээний үр дүнгээр нийт багш нарыг нийслэл, аймгийн төв, сум-баг гэсэн 3 байршилд бүлгийн багш, хөгжмийн багш, биеийн тамирын багш гэсэн ангилал /цаашид

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"кластер" гэх/-аар доор дурдсан индексийн 6 түвшинд үнэлж мэдээллийн системд байршуулна: 4.4-д "Энэхүү журмын дагуу хийсэн багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг доор дурдсан хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож олгоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтооо

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 3312 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж, ирцийн бүртгэлд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах

#### **3.2.2 Дотоод хяналт, ур чадварын нэмэгдэл олголттой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тооцолгүйгээр сар бүр олгодог, тайлант онд ур чадварын нэмэгдэлд 30,021.7 мянган төгрөгийн олгогдсон ч үүнээс эд хариуцагчид 1,735.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байхад няравын тайлан гаргалт хангалтгүй байгаа нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;"; 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3-д "илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;"; Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А10/9 тоот тушаалын 10-д "Улс, бүс, олон улсын амжилт гаргасан бол 25 хувийн нэмэгдэл олгоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваариалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгохгүй, ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн ур чадварын нэмэгдлийг олгох

### 3.2.3 Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн программыг шинэчлэн Си Ти Эс ХХК-ний СТС санхүүгийн программыг №ТА25/003 дугаартай гэрээ байгуулан ашиглаж байгаа ч данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэж тус тус заасан байна. Ажил гүйлгээ үйл явцыг мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба холбогдох хугацааны санхүүгийн тайланд тайлагнана. 14.-т"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг данс бүртгэл тусгах

### 3.2.4 Хүүхдийн хоол хүнсний зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд шоколадны крем 270 ширхэг, варень 425 ширхэг буюу чихэрлэг зүйл их хэмжээгээр хоол хүнсэндээ хэрэглэсэн, шатахууны зарцуулалт хангалтгүй, хүүхэд хамгааллын зардлыг арга зүйчийн дансаар гарган сургалтад зарцуулсан ч анхан шатны баримтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны А/166, А/559, 222 дугаар "норматив батлах тухай" тушаалаар 1."Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт"-ыг нэгдүгээр, "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ", гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоол хүнсэнд сахарын агууламж ихтэй бүтээгдэхүүн байнга хэрэглэхгүй, аймгийн Боловсролын газраас баталсан хоолны цэсийг мөрдөн ажиллах, шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг	4	20,926.3			4	20,926.3	4	20,926.3	-	-	-	-
Дүн	4	20,926.3	-	-	4	20,926.3	4	20,926.3				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг	5	14,766.7	1	11,981.3			4	2,785.4	-	-	-	-
Дүн	5	14,766.7	1	11,981.3	-	-	4	2,785.4	-	-	-	-

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-